


2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай орны 9 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 9°C (48.2°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +12.1°C (53.8°F) –аас +19°C (66.2°F), бусад нутгаар 9.1°C –аас +12°C (48.4°F –аас 53.6°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 9 дүгээр сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 9 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 20.1-45 мм, бусад нутгаар 0.3-20 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт


2024 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 1.0°C-аар хүйтэн, ОЖД-аас 0.4°C-аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 18 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн дийлэнх буюу 89.1% нь дунджийн орчим, 8.5% нь дунджаас +1.0-ээс +3.0°C-аар дулаан, 2.3% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 28.6 мм тунадас орсон нь өмнөх жилээс 20.8%-иар бага, ОЖД-аас 62.3%-иар ахиу буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 8 дахь хур тунадас ихтэй сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 50.4% дунджаас ахиу, 9.3% нь дунджийн орчим, 40.3% нь дунджаас бага тунадас унасан байна.




Зураг 2. 2024 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 9 дүгээр сарын агаарын температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 дүгээр 10 хоногт нийт нутгаар харьцангуй дулаан (ОЖД-аас +0.3°C -аас +7.5°C дулаан), харин 2 дугаар 10 хоногт хэлбэлзэл ихтэй байсан. 3 дугаар 10 хоногийн ихэнх хугацаанд агаарын температур ОЖД-аас дулаан байсан ба сарын сүүлээр нийт нутгаар огцом хүйтэрсэн (ОЖД-аас -2.2°C -аас -7.6°C хүйтэн) байна. Хур тунадасны хувьд нийт нутгаар харьцангуй ахиу тунадас орсон ба 3 дугаар 10 хоногт өмнө болон зүүн бүс нутагт илүү их хур тунадас оржээ.



Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Ховдын Зэрэгт 32.7°C, үнэмлэхүй бага утга Завханы Цэцэн-Уулд -12.0°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Өмнөговийн Даланзадгадад 59°C, үнэмлэхүй бага утга Завханы Цэцэн-Уул, Баян-Өлгийн Ялалтад -16°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Говьсүмбэрийн Чойрт 28-ны өдөр 63.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 960.0гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 767.3гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Дорноговийн Хөвсгөлд 26м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд